

8

МОНГОЛЫН МАЛЧИН ӨРХИЙН АЖ АХУЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ЭДИЙН ЗАСГИЙН ЗАРИМ АСУУДЛУУД

Ц.Цэвээн

Монгол нутагт Шинэ чулуун зэвсгийн үеэс амьтадыг гаршуулж улмаар гэршүүлэн цаашдаа бэлчээрийн мал аж ахуй болгон хөгжүүлж ирсэн юм.

Монгол нутаг нэлэнхүй газар тариалан эрхлэхэд тохиромж муутай харин мал аж ахуй эрхлэхэд нэн тохиромжтой юм. Аливаа улс орон хамгийн тохиромжтой аж ахуйн салбараараа газар нутгаа эдэлбэрлэж байдаг зүй тогтолтой. Иймээс ч монголчуудын эрхэлдэг аж ахуй, эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй юм.

Монголчууд мал аж ахуй эрхлэж, ус бэлчээрийн сайныг даган нүүдэллэн амьдрах явцад аж ахуйгаа эрхлэн хөтлөх нэгж буй болжээ. Энэ нэгжийг өнөө үед малчин өрхийн аж ахуй хэмээх бөгөөд энэ нь нийгэм түүхийн хөгжлийн явцад хувьсан өөрчлөгдөн хөгжиж ирсэн байна.

Малчин өрхийн аж ахуйн дээд үеийн хэлбэр болох хүрээ нь овгийн хүйн үеийн нүүдэлчдийн зохион байгуулалтын хэлбэрүүдийн нэг юм. Чухамдаа аж ахуйг хөтлөх аргын хувьд нийтийн өмчинд тулгуурласан хүрээ, хувийн өмчинд түшиглэсэн айл гэсэн хэлбэрүүд зэрэгцэн оршиж байжээ.

Хүрээ нь Овгийн ясан болон цусан төрлийн холбоотой, ахлагчаа овгийнхон хүлээн зөвшөөрсөн, мал маллах, ан авлах, тариалан эрхлэх зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад овгийн харъяалалтай, үйл ажиллагааныхаа үр дүнг тус тусдаа эзэмших шаардлага хараахан бүрэлдээгүй байжээ.

Хүрээг эдийн засгийн талаас нь авч үзвэл хувийн өмч бүрэлдээгүй, овог нийтийн өмчтэй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь дан ганц гар хөдөлмөрөөр гүйцэтгэхэд тулгуурласан байх учир бүтээмж багатай. Тухайн цаг үед хүрээ оршин байх үндэслэл нь:

1. Хувийн өмч бүрэлдэн гүнгийрч чадаагүй.
2. Овог хоорондын тэмцэл нь тэднийг бөөн байж гадны довтолгоог няцаах мөн бусдын хүрээ рүү довтолж мал болон бусад эд юм дээрэмдэх.
3. Ажил амьдралын бүхий л ажиллагаа гар хөдөлмөр дээр тулгуурлагдгаас хамтын бөөн хүчээрээ ажил үйлсээ бүтээх, малаа ээлжлэн маллах зэрэг хөдөлмөрийн энгийн хоршилттой холбоотой байсан байна.

Гэвч Хүрээ нь аж ахуйн зохион байгуулалтаасаа илүү цэргийн зохион байгуулалт давамгайлж байжээ.

Хүрээ айлын зохион байгуулалт нь амьдралын түүхэн шалгуурт зохицсон нь цаашид хөгжих, зохицоогүй нь түүхийн тавцангаас хальдаг жамыг тойрч гараагүй.

Арван хоёрдугаар зууны сүүлчээр нүүдэлчин олон овог аймгуудыг нэгтгэх явц эрчимжиж 13 дугаар зууны эхээр Монгол хэмээх төрт улс байгуулагдаж харъяалан нэгтгэсэн овог аймгуудыг шинэ зохион байгуулалтанд татан оруулах шаардлага бодитойгоор бий болсон бөгөөд энэ зохион байгуулалтаа овгийн үеийн хэв хуулинд үндэслэн хууль зүйг боловсруулан зохицуулжээ.

Феодалын харилцаа ялан, хаант төрт улс байгуулагдаж байх явцад овгийн байгуулал задран түүний халааг хувийн өмчинд тулгуурласан жижиг нэгж хэсгүүдэд зохион байгуулсан явдал юм. Нийгмийн ийм жижиг нэгжийг "айл" хэмээн нэрлэсэн байна.

Феодалын төрт улсаас овог хоорондын тэмцэлдээнийг таслан зогсоож нэгтгэн хууль зүйгээр зохион байгуулж ягштал биелүүлэх болсон нь овог хоорондын болзошгүй тэмцэлд бэлтгэгдсэн, бэлчээр нүүдлийн мал аж ахуйн зохион байгуулалтын нүсэр том бүтэц болох хүрээ задарч төрийн хуульдаа захирагддаг хувийн өмчинд суурилсан нүүдэл бэлчээрийн нөхцөлд зохицсон авсаархан бүтэц болох өрх ам бүлээс бүрдсэн "айл" хэмээх нийгэм аж ахуйн нэгж буй болсон байна.

Төр улс нэгэнт байгуулагдаж нийгэм даяараа хууль цаазаар зохицогдох болсон үед овог хоорондын тэмцэл намдаж дэвшил буй болон бэлчээр нүүдлийн мал аж ахуйн тухайн үеийн сонгодог зохион байгуулалтын хэлбэр болох "айл"-д хүрээ болон түүний дараачийн завсарын хэлбэрүүд байраа тавьж өгчээ.

Монгол хэлний товч тайлбар тольд "айл" хэмээх нь

1. нэг өрх гэр
2. зэргэлдээ орших
3. хуучирсан албаны юм хадгалах газар, албаны тариа зөөх эрчүүдийг захирах мянгатын хэрэг шийтгэх газар гэж тайлбарлажээ.

Эхний тайлбар нь тухайн сэдэвтэй холбогдох ба айлыг зөвхөн гаднах хэлбэрийн байдлаар тайлбарласан бөгөөд түүний бүрэлдэхүүний чухал хэсэг болсон ам бүлийг орхижээ, чухамдаа нэг гэр өрх-ам бүл гэсэн бол тохирох мэт.

Ер нь түрэг хэлний язгуурт багтдаг ард түмний хэллэгт “айл” нь “аул” гэх байдлаар бичигдсэн байдаг. Тухайлбал: Дагестаны ардын яруу найрагч Расул Гамзатов “... миний хот аул, гэрийн босго, төрсөн гал голомтоос минь миний орчлон бас эхэлдэг юм” гэжээ.

Айл хэмээх нь нэгэн хувиарлал ангилалд хамаарагдах /ай хүй/ хэмээхийн /айн/ үндсэнд /л/ дагавар залгаж /айл/ хэмээх нэр үүссэн гэж эрдэмтэд нотолдог. Дээрхээс учиглан үзэхүл анхандаа эцэг эх, үр хүүхдийн болон зарим тохиолдолд ахан дүүс, төрөл төрөгсдийн холбоо хэлхээн дээр үндэслэж, нүүдэлчин монголчуудын аж төрөл, амьжиргаа, эдийн засгийн үндэс болсон мал аж ахуйгаа эрхлэн хөтөлж амь зуулгаа хэвийн явуулах нөхцлийг бүрдүүлдэг тийм нэгдлийг айл гэж үзэх үндэстэй юм.

Айлын өвөрмөц өөр нэг хэлбэр бол саахалт айл болно. Саах тавих нь бог мал ногоонд цадаж сүү орох үеэс намар сааль татран бог ширгэх хүртэл үргэлжлээд аяндаа орхигдон дараа жил ахин сэргэдэг жамтай.

Айлаас гадна “өрх гэр”, “өрх ам”, “өрх”, “гэр бүл”, гэсэн нэр томъёог түүхэн сурвалж болон данс бүртгэлд тэмдэглэж иржээ. Энэ нь гэр түүний нэг тодорхой хэсэг болох өрхөөр харгалзуулан тэнд амьдардаг хүмүүсийг илэрхийлсэн ойлголт бөгөөд чухамдаа “айл” хэмээх үг ойлголтын хүрээнд хамааралтай юм гэдгийг манай эрдэмтэд эртний тэмдэглэжээ.

Хөдөлмөрийн энгийн хоршилтын үндсэн дээр бүрдсэн, хэд хэдэн айлыг хот айл гэдэг. Хот айл нь газар, бэлчээр усыг нийтээр ашиглаж эзэмшин, харин мал сүрэг, хөдөлмөрийн хэрэгслийг хувьдаа өмчилж байдаг. Ингэж нийтлэг болон хувийн шинжтэй зүйлс хосолж байгааг хөдөөгийн хүй хэмээдэг байна. Энэ их эртнээс уламжлалтай.

Хот айл нь бэлчээр нүүдлийн мал аж ахуйн хөгжлийн үр дүнд урган гарч ирсэн мал аж ахуй эрхлэх хөдөлмөр зохион байгуулалтын хамгийн идэвхитэй хэлбэр бөгөөд хөгжлийн явцад буй болсон боловч дараачийн өндөр дээд хэлбэрийнхээ үр хөврөл юм.

Манай зарим судлаачид хот айл нь мал аж ахуйн цаашдын хөгжлийн үндсэн хэлбэр гэж үзэх өнгө аяс илэрдэг. Бид үзэхдээ хот айл нь түүхэн хөгжлийн явцад үүргээ гүйцэтгэж, хөгжлийнхөө аагинд хүрсэн харин нийгмийн хөгжлийн жамаар бүрэлдэн тогтох хамгийн тохиромжтой дараагийн хэлбэр байдлаа эрэлхийлж байна гэж ойлгодог.

Мал аж ахуй эрхлэн хөтөлдөг “айл”-ын хэлбэр буй болсон цагаасаа эхэлж бүтэц тоогоороо болон нийгэмд эзлэх байр сууриараа харилцан адилгүй байдалтай, харин тэдний түгээмэл шинж нь мал аж ахуйн эрхлэн өвс ургамал, усны байдалтай уялдуулж жилийн улирлын өнгө аясад тохируулан нүүдэллэдэг чухамдаа бэлчээрийн хүрэлцээ, ургамлын ургац, өвсний байдал, малын тооны хамаарлаас үүсч гарсан зөрүүг малчид нүүдэллэн зохицуулж байдаг бөгөөд ган зуд тохиолдвол

тийм нутгаас хулжин зунтай буюу өнтэй нутагт очиж нутагладаг.

Монгол мал нь бэлчээрт дулдуйддаг учир бүтээгдэхүүн нь бага боловч хямд байдаг. Хэрвээ байр, тэжээл, усны хангамжийг шийдвэрлэлээ ч түүний бүтээгдэхүүний гарц нэг хэвэндээ байдгаас орлого нь зардлаа нөхөж чаддаггүй. Иймээс ч мал нь бэлчээрээ даган малчид малаа дагаж нүүдэллэж аж төрөх нь амьдралаас урган гардаг бөгөөд нүүдэл нь эдийн засгийн зохих үндэслэлтэй холбоотой.

Өнө эртнээс нааш мал маллагааны явцдаа малчин монголчууд өөрсдийнхөө байгаа тэр газар нутгийнхаа газар зүй, цаг уур, хур тунадас, өвс ургамлын төрөл түүний ургац, тархалт усан хангамж, салхи жаврын чиглэлийг ажиглан таньж мэдсэнийхээ дүнд жилийн улирлын аястай зохицуулж мал сүргийнхээ биологи, физиологийн онцлогт уялдуулан өвөлжөө, хаваржаа, зуслан, намаржааны нутаг бэлчээрийг хүрээлэн байгаа орчинтойгоо тохируулан буй болгосон нь зөвхөн мал аж ахуйн улирлын байршлын тухай асуудал биш Монгол орныхоо газар нутгийг мал аж ахуйгаар эдэлбэрлэх цогцолбор арга зүй бөгөөд ахмад үеийнхнээс өнөө болон хойч үедээ удамлуулсан оюуны болон материалын үнэт сан, асар их үнэт өв хөрөнгө юм. Чухамдаа бэлчээрийн малыг зуслангийн нутагт өвөлжүүлэх, өвөлжөөний нутагт зусааж болдоггүй сөрөг нөлөөтэй байдаг нь малчид газар нутгийн орчныг гүнзгий таньж мэдсэнтэй холбоотой.

Малчин айлын эдийн засгийн үндэс нь мал аж ахуй учир таван хошуу малтай байхыг айл бүр сонирхох боловч газарзүй, цаг уур, бэлчээрээс их хамааралтайгаас гадна нийгмийн хэрэгцээ, тухайн айл өрхийн эзний сонирхол, таашаал чадвараас хамаарч аль нэг буюу хэд хэдэн төрлийн мал давамгай байх нь элбэг. Тухайлбал, ойт хээрийн бүсэд үхэр, хонь, адуу, хээрийн бүсэд адуу, үхэр, хонь говийн бүсэд тэмээ, ямаа, өндөр уулын бүсэд хонь, адуу, үхэр зонхилсон байдалтай байдаг.

Түүхэн хөгжлийн явцад “айл” –ыг овгийн язгууртан, улмаар Их Монгол улсын үед мянгатын захирагчийн харъяа захирагчид, хожуу үед отгийн ноёд, манжийн дарлал болон “Олноо Өргөгдсөн Богд хаант монгол улсын үед хошууны ноёдын захиргаанд явж иржээ.

Феодалын нийгмийн үед монголын малчид нь хаан санд татвар төлөх, өртөө улаа хийх зэрэг улсын албанд зүтгэхээс гадна эзэд ноёдод бүтээгдэхүүнээр болон биеэр гүйцэтгэх алба барьж иржээ. Тэд улсын харъяалалын сум албат, ноёны харъяаллын хамжлага албат, шашин сүм хийдийн харъяаны шавь албат нар байлаа.

Энэ үеийн малчин айл-өрхийн эдийн засаг, аж ахуйн үндэс болсон мал аж ахуй нь хүний өдөр тутамын хэрэглээг хангах шинж чанарын онцлогоос үндэслэн монгол хүн амарлангүй болж түүгээрч зогсохгүй мал аж ахуйгаа цаашид хөгжүүлэх талын ямар нэгэн дорвитой бүтээлч үйл ажиллагаа тухайн үеийн төрийн талаас ч хувь малчны талаас ч гарч байсангүй. Монголчууд нэгэн төрлийн аж ахуй эрхэлдэгээс таваар мөнгөний харилцаа хөгжөөгүй, дотоодын зах зээлийн хөгжил ч дорой байлаа.

Монгол оронд 1921 онд Ардын Хувьсгал ялсаны дараа Ардын Засгийн Газраас улс орны хоцрогдлын үндэс нь хамжлагын харилцаа гэж үзээд түүнийг халах явдлыг тэргүүн ээлжийн арга хэмжээ болгож тавьсан байна. Юуны өмнө эзэн - албатын харилцааг халах, нөгөө талаар тэдний үйлдвэрлэлд эзлэх байр суурь, үйлдвэрлэлийн хэрэгсэлтэй харилцах харилцаа, зохион байгуулалт хуваарилалтын харилцааг үндсээр нь өөрчлөх олон чухал шийдвэр гаргасан юм.

Ардын Засгийн Газраас 1922 оны нэгдүгээр сарын 25-нд хамжлагат ёсыг халах тухай тогтоол гарган мөн оны 9 дүгээр сарын 26-ны тогтоолоор феодалын хамжлага захирах эрхийн тамгыг хураахаар тогтоож хэрэгжүүлжээ. Ингэснээр феодалын үйлдвэрлэлийн харилцааг халж, бүх төрлийн албатууд олон янзын дарлалаас чөлөөлөгдсөн ардууд өөрсдөө аж ахуйгаа чөлөөтэй эрхлэн хөгжүүлж амьдралаа сайжруулан улмаар үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх бололцоо нээгдсэн юм.

Ардын засгийн газраас малчин ардын талаар явуулсан чухал бодлогуудын нэг нь ядуучуудыг жижиг таваар үйлдвэрлэгчид болгох зорилтыг тавьж хэрэгжүүлсэн.

Энэ үеийн малчин өрх нь нийгмийн үйлдвэрлэх хүчин, үйлдвэрлэлийн харилцааны хэлбэршил хөдөлмөр эрхлэлтийн агуулгаас шалтгаалан феодалын үеийн албат малчин өрх айлаас агуулгаараа ялгаатайн дээр хариуцан маллаж байгаа малын тоо, түүний өмчлөлтөнд гарсан зарим өөрчлөлттэй холбогдон малчин өрхийн дотоодод ч том өөрчлөлт гарсан юм. Ялангуяа газрыг улсын болгож бэлчээрийг нийтээр эзэмших болсоноор хамжлагаас чөлөөлөгдсөн малчин ардууд цөөн ч гэсэн малаа чөлөөтэй нүүдэллэн маллах болсон нь тэдгээрт амьдралаа сайжруулах нэг үндэс болсон.

Ардын Засгийн газраас авч явуулсан бодлогын дүнд ардын аж ахуйтнууд баян хоосон гэсэн хоёр туйл руу задрах биш харин дундажлагдах хандлагаар хөгжиж 1940 оны үест хөдөө аж ахуйд ажиллагсдын хагасаас илүү нь дунд аж ахуйтан болж, нийт малын 60 гаруй хувь нь тэдний мэдэлд байжээ.

1954 оны мал сүргийн тооллогын материалаас үзэхэд өрх аж ахуй, малын тоог бүлэглэн тодорхойлсныг үндэслэн багцаалхад 43000 орчим хот-айл, нэг хотод дунджаар 4-5 өрх, 400 гаруй мал байжээ.

1950-аад оны дунд үеэс манай оронд нэгдэлжих хөдөлгөөн эрчимтэй өрнөж нэгдлийн гишүүн малчин өрх олширч хөдөлмөрөө хорших нь нийтлэг үзэгдэл болж ирсэн юм. Энэ үеийн хот айлын дотоод агуулгад өөрчлөлт орж аливаа мөлжлөгөөс чөлөөлөгдсөн эрх тэгш агуулгатай малчин өрх айлуудын нэгдэл болж ирсэн юм. Энэ үеийн хот айл нь үндсэндээ аж ахуйн үйл ажиллагааны шаардлагаар нэгдэж, өмнө үед түгээмэлдүү байсан төрлийн холбоонд үүсдэг байсан хэлбэр ач холбогдол багатай болох хандлагатай байлаа.

Аливаа хоршооллогчдын эрхэм зорилго бол хөдөлмөрөө хоршин үйлдвэрлэл үйлчилгээ явуулсаны үр дүн нь тэдний амьдрал, аж төрлийг өмнөх төвшинөөс дээшлүүлэх явдал юм.

Манай орны хөдөө аж ахуйд үүссэн хоршоололын онцлог нь нэг төрлийн аж ахуй эрхэлдэг малчин ардууд хөдөлмөрөө хоршин үйлдвэрлэл, үйлчилгээний өөр салбар эрхэлж байсанд оршино.

Тэдний байнгын хөдөлмөр зохион байгуулалтад шилжих үндэс нь хөдөлмөрөө хоршсоны үндсэн дээр үйлдвэрлэл үйлчилгээний үр дүнд буй болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогыг хоршоололд оролцогсдынхоо хөдөлмөр зохицуулалтын харьцаагаар хуваарилж тодорхой хэсгийг дараагийн үйлдвэрлэл явуулах нөхцөл болгон хуримтлуулсан нь хоршоологчдын дундын хөрөнгө бүрдэж цаашид байнгын тасралтгүй үйл ажиллагаа явуулах бололцоо бүрдэж байжээ. Манай орны янз бүрийн бүс нутагт тарианы, жингийн, ангийн гэх мэт үйлдвэрлэл үйлчилгээний хэлбэрүүдтэй хоршооллын байгууллагууд үүсч хөгжиж байсан байна.

Энэ үеийн мал аж ахуй дахь хөдөлмөр зохион байгуулалт нь уламжлалт хөдөлмөрийн энгийн хоршилтын хэлбэр болсон хот айлын бүтцийг өөрчлөхөд хүргэсэн юм.

Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйн салбарт хөдөлмөр зохион байгуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор 1963 онд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн "Хөдөө аж ахуйн нэгдлийн мал аж ахуйд хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" 210/330 дугаар тогтоолыг баталж хэрэгжүүлсэн юм. Уг тогтоолоор хөдөө аж ахуйн нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалтыг бригад, хэсэг, сууриар зохион байгуулахыг заасан юм. Энэ нь амьдрал дээр бригад хэсгийн зохион байгуулалт биеллээ олж хэрэгжиж чадаагүй, харин бригад суурь гэсэн хоёр шаттай зохион байгуулалт 1992 онд хөдөө аж ахуйн нэгдлүүд тарах хүртэл бодитойгоор ажиллаж байсан юм.

Тухайн үедээ хэсгийн зохион байгуулалт хэрэгжсэн газруудад бригад гэсэн дамжлага үгүй болдог тохиолдол зарим нэгдэлд ажиглагдаж байв.

Суурь бол нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалтын анхан шатны хэлбэр, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үндсэн нэгж байлаа. Суурь нь харъяалагдсан бригадынхаа нутаг дэвсгэрт малаа маллаж, оногдсон үйлдэхүүнээ төлөвлөгөөгөөр нэгдэлдээ тушаадаг учраас бүтээгдэхүүн үйлдвэрлэгч болохоос таваарын эзэн биш байлаа. Малыг дагнаж төрөлжүүлэн суурь зохион байгуулдаг учраас нэгэн төрлийн болон нэг янзын нас хүйсний малаар голдуу суурь зохион байгуулдаг байв. Иймд малынхаа аяст таарах нутагт нутаглах учир нэлээд таруу байрлалтай байв.

Суурийн хүн, мал, бэлчээр, нутаг тогтмол байдаг учир задрал бараг үгүй, ихэнхи суурь нэг өрх айлаас бүрдэж байлаа. Учир нь нэгдлүүдэд аль ч төрлийн нэгж малын хариулга маллагааны хөлс маш бага байсантай холбоотойгоор олон толгойгоор суурилдаг, харин төл бойжуулах, ноос авах, улсад тушаасан мал махны үнэлгээ харьцангуй өндөр байв. Чухамдаа нэгдлүүдэд байсан түгээмэл үзэгдэл бол бүтээгдэхүүн авч ашиглахтай уялдсан хөлсний үнэлгээг өндөр, харин бүтээн буй

болгоход зарцуулж байсан хөлсийг бага тогтоосон нь суурь нэг өрх айлаар байхын үндэс болсон юм.

Сууриар мал аж ахуйг зохион байгуулах үед нэг төрлийн малыг олон жил дагнан малласан малчид нарийн мэргэшсэн байсан. Малчин айлаар суурь зохион байгуулалтыг хэрэгжүүлсэн нь түүнд ололт дутагдлын аль аль нь байсныг тэмдэглэх хэрэгтэй.

1992 онд Аж ахуйн нэгжийн тухай, мөн өмч хувьчлах хуулиуд гарч хувьчлах явдлыг тухайн нэгдлийн гишүүд өөрсдөө шийдсэнээр юуны өмнө мал хувьчлагдсанаар малчин өрхийн аж ахуй буй болсон юм.

Одоо манай хөдөөд мал бүхий 369.9 мянган өрхтэй түүний 189.9 мянга нь малчин өрхийн аж ахуй юм. Малчин өрхийн аж ахуй урьд өмнө байсан ардын аж ахуйтнаас өөр юм. Учир нь ардын аж ахуйтнуудын мал сүрэгт улсаас төлөвлөгөө оноож ашиг шимийг нь албан журмын оногдлоор төвлөрүүлэн авч, уг төлөвлөгөөт даалгаварын биелэлтэнд хуулиар хяналт тавьдаг байв.

Өнөөгийн малчин өрхийн аж ахуй нь зах зээлийн харилцааны жамын дагуу эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйл ажиллагаагаа бие даан юуг яаж, хэнд хэзээ гэдгийг өөрөө шийдвэрлэж байна. Малтай өрх, малчин өрхийн аж ахуйн аль аль нь малтай боловч улсын буюу эсвэл ямар нэгэн байгууллагад ажилладаг, аминдаа зохих тооны малтай тэр нь аж ахуйдаа туслах шинж чанартай ашиглагддаг өрх айлыг малтай өрх гэж үзэх үндэстэй.

Малчин өрхийн аж ахуй гэдэг нь дан ганц малдаа тулгуурлан түүнийхээ ашиг шимээр аж төрөл, эдийн засгийн бүх асуудлаа шийддэг. Жилийн турш малаа маллаж бэлчээр нүүдлийн мөр хөөх явдал зонхилсон тэр өрх аж ахуйтныг хэлнэ.

Малчин өрхийн аж ахуй нь урьдын адил (газар) бэлчээр, усанд тулгуурлан, мал сүргээ адуулан ашиг шимэд нь дулдуйдан амьдарч байгаа боловч зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан сүргийн бүтцээ зохицуулах хандлага түгээмэл байна. Тухайлбал: Сүрэгт эзлэх эр малын хувийн жин өсөж байгаагаас гадна ямааны ноолуурын үнэ нэмэгдсэнээр сүүлийн 10 жилд ямааны тоо 2.2 дахин өссөн нь үүнийг нотолж байна.

Монгол орны өргөн уудам газар нутагт хот суурины байршилт зам харилцаа болон дэд бүтцийн байдлаас үүдэн малчин өрхийн аж амьдрал хөгжлийн төвшинд их ялгаа гарч байна. Хот суурин бүхий төвийн районуудад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ их байгаатай хамааралтайгаар ойролцоох нутгийн малчин өрхийн амьдралд эерэг нөлөөтэй байхад, энэ хэсгээс алслагдах тусам урвуу хамааралтай байна. Үүнээс үүдэн төвөөс алслагдах тусам малчин өрхийн аж ахуйд буй болсон бүтээгдэхүүний үнэ хямдарч, тэдний өдөр тутмын өргөн хэрэгцээт зүйлийн үнэ өсдгөөс төвийн район руу нүүдэллэн шилжих хөдөлгөөн ихэсэж байна.

Энэ нь зах зээлийн өнөөгийн нөхцөлд малчин өрхийн аж ахуйн талаархи улсын бодлого, төрийн зохицуулалт, хууль эрхийн асуудал, бүс нутгийн хөгжлийн бодлого учир дутагдалтай байгаатай холбоотой гэхээс өөрөөр тайлбарлах аргагүй байна.

Малыг хувьчилсанаар малчин өрхийн амьдрал жигд сайжирдаггүй гэдгийг өнгөрсөн туршлага нотоллоо. Ер нь аж ахуй эрхлэлтийн үйл ажиллагаанд ямар нэг чанарын өөрчлөлт гараагүй нөхцөлд тухайн аж ахуй эрхлэгчдийн бүтцэд ч тодорхой өөрчлөлт гардаггүйг түүхэн тоо баримт нотолж байна. Тухайлбал, нэрт түүхч Ц.Насанбалжирын бүтээлд 1841 оны Сэцэн Хан аймгийн өрх-ам, малын тооны судалгаанд тусгаснаар өрх-амын 12 хувийг эзэлж байсан ноёд язгууртнуудад бүх малын 30 хувь, тэдгээрийн нэг өрх амд 126-3051 мал оногдож байхад сум-албат, хамжлага, шавь албат нар өрх-амын 88, бүх малын 70 хувь эзэлж, эдгээрийн нэг өрх-амд 30-96 толгой мал оногдож байжээ. Зөвлөлтийн эрдэмтэн С.К.Рощин 1927 онд монголын мал аж ахуйд хийсэн судалгаанаас үзэхэд ардын аж ахуйтны 63.7 хувьд бүх малын 14.4 хувь оногдож байсан ба үүний 3.5 хувь нь малгүй, 60.2 хувь нь 100 хүрэхгүй толгой малтай байхад ардын аж ахуйтны үлдэх 36.3 хувьд бүх малын 84.5 хувь нэг өрхөд 21-1800 бод оногдож байлаа.

Одоо манай хөдөө аж ахуйд 200 шахам мянган малчин өрхийн 72 хувь нь 100 хүрэхгүй, 10 хувь нь 200 орчим малтай, үлдэх хувь нь 200-аас дээш тооны малтай байгаа нь дээрхийг баталж байна.

Малчин өрхийн аж ахуй нь өнөөгийн монгол орны хоцрогдлын голыг өөртөө агуулсаар байна. 1992 оноос хойш малыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга туулга орхигдсоноос жил бүр бүх малын 2.3 хувиас багагүй нь зүй бусаар хорогдож байгаагаас гадна зарим гоц халдварт өвчин сэргэх хандлагатай болов.

Мөн малчин өрхийн аж ахуйн талаар тусгай боловсруулсан нийгмийн боловсролын бодлого үгүйгээс хүүхдийн сургууль завсардалт нэмэгдэж, их дээд сургуулиудад малчдын хүүхэд элсэх явдал бараг үгүй болсон байна.

Сүүлийн жилүүдэд малын тоо нийт дүнгээр өсөж байгаа боловч бүтцээр нь авч үзвэл ямаа өндөр хурдацтай өсөж, хонь тэмээ буурсаар байна. Малын өсөлтөд нөлөөлж буй гол хүчин зүйл нь малын тавааржилт эрс буурсантай холбоотой гэх үндэстэй байна.

Мөн мал аж ахуйн салбарт манай эрдэмтэдийн бүтээсэн өндөр ашиг шимт мах сүүний чиглэлийн сэлэнгэ үүлдэрийн үхэр, нарийн болон хагас нарийн ноост, Ерөө, Хангай, Орхон, Байдраг хонь, мах-ноосны чиглэлийн Торгууд үүлдрийн хонинууд мөхсөн буюу мөхлийн ирмэгт тулаад байна. Энэ бүгдээс үзэхэд малчин өрх, мал аж ахуйн талаархи төрийн цэгцтэй бодлого шаардлагатай бөгөөд үүний тулд мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дахин боловсруулдаг үндэсний аж үйлдвэрлэлийг сэргээхээс эхлээд малчин өрхийн хөдөлмөрийн хоршилтыг бүхий л талаар дэмжих хууль эрхийн актуудыг бүрдүүлэх цогцолбор арга хэмжээ хэрэгтэй байна. Энэ нь зөвхөн мал аж ахуйн асуудал бус улс орны цаашдын хөгжлийн тухай асуудалтай

салшгүй холбоотой. Ийм нөхцөл бүрдүүлсэн тохиолдолд малчин өрхийн аж ахуй өөрийн цаашдын хөгжлийнхөө дүр төрхийг олж зах зээлд хөлөө нийлүүлэн, Монгол орныхоо хөгжилд зохих хувь нэмэр оруулах аар эрэлийн замд явж байна.